



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн ТОГТООЛ

1975 оны 2 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 104

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотын гүйцэтгэх захир-
гааны зохион байгуулалт, орон тоог
батлах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны зохион байгуулал-
тыг дор дурьдсанаар баталсугай:

- а/зохион зааварлах хэлтэс;
- б/санхүүгийн хэлтэс;
- в/төлөвлөгөөний комисс;
- г/хөдөлмөр, нийгэм хангамжийн хэлтэс;
- д/статистикийн товчоо;
- е/хөдөө аж ахуйн хэлтэс;
- ж/эрүүлийг хамгаалах газар;
- з/ардын боловсролын хэлтэс;
- и/соёлын хэлтэс;
- к/цэрэг, иргэний хамгаалалтын хэлтэс;
- л/аж ахуйн хэлтэс.

2. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны аппаратаас 12
орон тоог хотын 4 районы гүйцэтгэх захиргаанд шилжүүлэн, район
тус бүрт орон сууц гудамжны хороо хариуцсан зохион байгуулагч 1,
ерөнхий эмч 1, соёлын асуудал хариуцсан байцаагч 1-ийн орон
тоо бий болгож, хотын гүйцэтгэх захиргааны орон тоог 1 дүгээр
хавсралтын ёсоор 89 нэгжээр тогтоосугай.

2.

3. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны дарга, орлогч, хариуцлагатай нарийн бичгийн дарга нарын ажлын хуваарийг 2 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

4. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаа /н.БАЛБАР/-д зөвшөөрөх нь:

а/хотын гүйцэтгэх захиргааны архитектурын газар, барилга захиалагчийн товчоо, барилгын зураг, төсвийн товчоог нэгтгэн, Улаанбаатар хотын барилга-архитектурын газар байгуулж аж ахуйн тооцоогоор ажилдуулсугай;

б/хот тохижуулах газрын амьд цэцгийн аж ахуй, хиймэл цэцгийн үйлдвэр, мод үржүүлэх аж ахуй, арчлан хамгаалах аж ахуйг нэгтгэн хот цэцэрлэгжүүлэх трест байгуулж аж ахуйн тооцоогоор ажилдуулсугай;

в/Улаанбаатар хотын гэрэл чимэглэлийн үйлдвэрт цахилгааны тасгийг нэгтгэн, Гэрэлтүүлэг, чимэглэлийн үйлдвэр гэж нэрлэн аж ахуйн тооцоогоор ажилдуулсугай;

г/Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны усны аж ахуйн хэлтсийг татан буулгаж байгаатай холбогдуулан, тус хэлтсийн гүйцэтгэж байсан үүргийг ус сувгийн ашиглалтыг эрхлэх газарт шилжүүлэн тус газрыг цаашид Улаанбаатар хотын Усны аж ахуй, ашиглалтыг удирдах газар гэж нэрлэн Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны харьяанд ажилдуулсугай.

5. Нийслэлийн кино театр, нүүдлийн ба суурин киноны удирдлагыг нэгтгэн, кино контор байгуулж, гүйцэтгэх захиргааны харьяанд аж ахуйн тооцоогоор ажилдуулахыг Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаа /н.БАЛБАР/, Соёлын яам /н.ЛУВСАНВАНДАН/-д зөвшөөрсүгэй.

3.

6. "Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаа, түүний харьяа газар, байгууллагын суудлын автомашины эрхийн тухай" Сайд нарын Зөвлөлийн 1969 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 418 дугаар тогтоолын I дүгээр хавсралтын I-д "дуудлагын автомашин 5" гэснийг I-ээр хорогдуулсугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан, 3 дугаар хавсралтад дурьдсан Сайд нарын Зөвлөлийн тогтоол болон тогтоол, захирамжийн заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Сайд нарын
Зөвлөлийн дарга

Ж. БАТМӨНХ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн
Хэрэг эрхлэх газрын дарга

Б. БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн

эрхлэгчийг

M. Jhargbaa /М. ЖХАГБАА/



Сайд нарын Зөвлөлийн 1975 оны 104
дүгээр тогтоолын I дүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ТӨВ АППАРАТЫН ОРОН ТООНЫ
Ж А Г С А А Н Т

№ :	Албан тушаал	: Орон тоо
1.	Дарга	1
2.	Нэгдүгээр орлогч дарга бөгөөд төлөвлөгөөний комиссын дарга	1
3.	Орлогч дарга	2
4.	Хариуцлагатай нарийн бичгийн дарга	1
5.	Газрын дарга	1
6.	Хэлтсийн дарга	8
7.	Товчооны дарга	1
8.	Төлөвлөгөөний комиссын орлогч дарга	1
9.	Ахмадын зөвлөлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга	1
10.	Газар, хэлтсийн орлогч	2
11.	Боловсон хүчин, гадаад асуудал хариуцсан референт	1
12.	Брөнхий нягтлан бодох	1
13.	Ахлах мэргэжилтэн, байцаагч	4
14.	Байцаагч, зааварлагч, мэргэжилтэн	43
15.	Хуулийн мэргэжилтэн	1
16.	Цэрэг, иргэний хамгаалалтын туслах	3
17.	Инженер, агрономич, зоотехникч	4
18.	Байцаагч, нягтлан бодох	3
19.	Даргын нарийн бичгийн дарга	1
20.	Бичиг хэргийн эрхлэгч	1
21.	Ахлах бичээч	1
22.	Бичээч	3
23.	Оператор-бичээч	1
24.	Командант-нярав	1
25.	Архивын эрхлэгч	1
26.	Архивын фондоч	1
	ДҮН	89



УЛААНБААТАР ХОТЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
 ДАРГА, ОРЛОГЧ, ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН
 ДАРГА НАРЫН АЖЛЫН ХУВААРЬ

1. Дарга

а/хотын бүх ажлыг удирдах, зохион байгуулалт, боловсон хүчний асуудал;

б/хотын санхүү, банкны асуудал;

в/цэрэг, иргэний хамгаалалтын асуудал;

г/шүүх, арбитер, цагдан сэргийлэхийн асуудал;

д/хөдөө аж ахуй, байгаль хамгаалах асуудал.

2. Нэгдүгээр орлогч дарга бөгөөд төлөвлөгөөний
 КОМИССЫН ДАРГА

а/төлөвлөгөө, статистик, хөдөлмөр, нийгэм хангамжийн асуудал;

б/хотын худалдаа, бэлтгэл, нийтийн хоол, тээврийн асуудал;

в/социалист уралдаан, шинэ санаачилга, тэргүүн туршлагын асуудал.

3. Нийгэм, соёл эрхэлсэн орлогч дарга

а/эрүүлийг хамгаалах, ардын боловсрол, соёл, биеийн тамирын асуудал;

б/хотын телефон, радио ашиглалтын асуудал.

4. Барилга, нийтийн үйлчилгээ эрхэлсэн
 орлогч дарга

а/хотын архитектур, барилгын асуудал;

б/орон сууцны хуваарилалт, аниглалт болон дулаан, цахилгаан, усан хангамжийн асуудал;

в/ахуйн ба мэргэжилтний үйлчилгээний асуудал;

г/хот тохижуулах болон иргэдийг үйлчлэх товчооны асуудал.

5.Хариуцлагатай нарийн бичгийн дарга

а/хот, районы ардын депутатуудын хурал, тэдгээрийн гүйцэтгэх захиргааны асуудал;

б/хотын гүйцэтгэх захиргааны дотоод аппаратын асуудал;

в/хөдөлмөрчдийн эрэлт хүсэлт, санал, гомдол, иргэний асуудал;

г/төрийн захиргааны олон нийтийн байгууллага, хот дахь улсын архивын асуудал;

д/хотын гүйцэтгэх захиргааны төсөв аж ахуйн асуудал.



**ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТОГТООЛ БОЛОН
ТОГТООЛ, ЗАХИРАМЖИЙН ЗААЛТ**

1. "Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалт, орон тооны тухай" Сайд нарын Зөвлөлийн 1968 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 185 дугаар тогтоолын I дүгээр зүйл, мөн 2 дугаар зүйлээр батлагдсан орон тоо;
2. "Орон тоо бий болгох тухай" Сайд нарын Зөвлөлийн 1969 оны II дүгээр сарын 20-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд нэмсэн орон тоо;
3. "Тэтгэврийн асуудал хариуцсан зарим орон тооны тухай" Сайд нарын Зөвлөлийн 1970 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 292 дугаар захирамжийн 2 дугаар зүйл;
4. "Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд ерөнхий архитектурын орон тоо бий болгох тухай" Сайд нарын Зөвлөлийн 1969 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 90 дүгээр тогтоол;
5. "Орон тоо бий болгохыг зөвшөөрөх тухай" Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 46 дугаар тогтоолын 3 дугаар зүйлээр Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд нэмсэн орон тоо;
6. "Улаанбаатар хотын зарим районы гүйцэтгэх захиргаанд орон тоо нэмэгдүүлэх тухай" Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 265 дугаар тогтоолоор хотын гүйцэтгэх захиргаанд нэмэгдүүлсэн орон тоо;
7. "Орон тоо нэмэгдүүлэх тухай" Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 409 дүгээр тогтоолын I дүгээр зүйлээр нэмэгдүүлсэн Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны Эрүүлийг хамгаалах газрын орлогч даргын орон тоо, мөн тогтоолын 2 дугаар зүйл;

8. "Малчин залуучуудын боловсролыг дээшлүүлэх зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1972 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 147 дугаар тогтоолын 5 дугаар зүйлээр Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны Ардын боловсролын хэлтэст нэмэгдүүлсэн хөдөлмөрчдийн боловсролын асуудал эрхэлсэн байцаагчийн орон тоо;

9. "Орон тоо бий болгох тухай" Сайд нарын Зөвлөлийн 1972 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 329 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл;

10. "Хөдөө аж ахуйн удирдлага, зохион байгуулалтанд зарим өөрчлөлт оруулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1972 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 232 дугаар тогтоолын 9 дүгээр зүйлээр батлагдсан орон тоо;

11. "Усны аж ахуйн хэлтсийн орон тоо батлах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1972 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд нэмэгдүүлсэн хэлтсийн дарга 1, мэргэжилтэн 2-ын орон тоо;

12. "Статистик бүртгэлийн ажлыг хэрхэн удирдаж байгаа тухай" Сайд нарын Зөвлөлийн 1972 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 94 дүгээр тогтоолын 8 дугаар зүйлээр Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны Статистикийн товчоонд нэмэгдүүлсэн орон тоо;

13. "Улсын нийгэм хангамжийн ажлыг төвлөрүүлэн зохион байгуулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1974 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 124 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлээр батлагдсан Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны Хөдөлмөр, нийгэм хангамжийн хэлтсийн орон тоо;

14. "Орон тооны тухай" Сайд нарын Зөвлөлийн 1972 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 86 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд нэмсэн орон тоо;

3.

15. "Ард иргэдийн дунд тэтгэврийн даатгал явуулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1973 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 218 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлээр Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд нэмэгдүүлсэн орон тоо;

16. "Халтэс байгуулах, орон тоо нэмэгдүүлэх тухай" Сайд нарын Зөвлөлийн 1973 оны 11 дугаар сарын 16-ны өдрийн 417 дугаар тогтоолын 2 дугаар зүйл;

17. "Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны хүсэлтийн тухай" Сайд нарын Зөвлөлийн 1973 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 30 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны соёлын халтэст бий болгосон орон тоо;

18. "Орон тооны тухай" Сайд нарын Зөвлөлийн 1972 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 343 дугаар тогтоолын 2 дугаар зүйлээр Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд нэмэгдүүлсэн орон тоо;

19. "Хувийн журмаар оршин суугаа гадаадын иргэдийг нийгмийн тустай хөдөлмөрт оруулж байх журмын тухай" Сайд нарын Зөвлөлийн 1967 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 313 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлээс орон тооны холбогдолтой хэсэг;

20. "Иргэний хамгаалалтын талаар авах арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1969 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 403 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 15 дугаар зүйл;

21. "Улаанбаатар хотын барилгын засварын трестийн ажлын талаар авах арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1968 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 424 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн "в" заалт;

22. "Зарим авто аж ахуйг нэгтгэх ба шинээр байгуулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1960 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 54 дүгээр тогтоолын I дүгээр зүйл, 2 дугаар зүйлийн "б", "г"-гээс бусад заалт;

23. "Аймаг, хот, сум, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, орлогчдын ажлын хуваарийн тухай" Сайд нарын Зөвлөлийн 1968 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 398 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт;

24. "Хотын мод үржүүлэх аж ахуй байгуулах газрыг өөрчлөх тухай" Сайд нарын Зөвлөлийн 1961 оны II дүгээр сарын 15-ны өдрийн 584 дүгээр тогтоолоос мод үржүүлэх аж ахуй байгуулах тухай заалт;

25. "Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалт, орон тоо, цалингийн фондыг батлах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1961 оны II дүгээр сарын 24-ний өдрийн 601 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн "а" заалт.